

МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2020 ОНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
 ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2020 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана)	Засгийн газрын 2018 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр Хөтөлбөрийн зорилго: Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчин гарах, тархах шалтгаан нөхцөлийг хязгаарлан эрүүлжүүлэх арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлж, халдварт өвчингүй тайван байдлаа дотооддоо болон гадаад оронд баталгаажуулан хадгалж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэхэд оршино.
2	Санхүүжилтийн эх үүсвэр	5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ: 5.1.1. улсын төсөв, олон улсын байгууллага, гадаад орны зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт; 5.1.2. гоц халдварт, халдварт, зооноз өвчин дэгдсэн онцгой байдлын үед улсын болон орон нутгийн төсөв; 5.1.3. төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж; 5.1.4. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Мал эмнэлгийн ерөнхий газар 4 жил, 2018-2021 он Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар, МЭЭСБУЛ, УМЭАЦТЛ, Биокомбинат ТӨХХК
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 2.2.1: мал эмнэлгийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох Зорилт 2.2.2: мал, амьтны гоц халдварт болон халдварт, шинэ болон дахин сэргэж байгаа өвчнийг эрт илрүүлэх тандалтыг өргөжүүлэх замаар өвчнийг хяналтад авч, халдварт өвчингүй тайван байдлыг лабораторийн шинжилгээний үр дүнг харгалзан бүс нутгаар баталгаажуулах; Зорилт 2.2.3: мал, амьтны гоц халдварт, зооноз, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг шинжлэх ухааны нотолгоо, тархвар зүйн судалгааг үндэслэн төлөвлөх замаар бүс нутгаар нь хяналтад авах; Зорилт 2.2.4: мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар гоц халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох; Зорилт 2.2.5: мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтэн, малын эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх; Зорилт 2.2.6: малчин, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг мал, амьтны эрүүл мэнд, түүнтэй шууд холбогдох нийтийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээллээр хангаж, үр дүнг сурталчлан таниулах.

5	Зардал	Төсөв (Нийт зардал)	Улсын төсвийн 35,6 тэрбум төгрөг		
		Үүнд:	Төсөв (2020 он)	Гүйцэтгэл	Хувь
		Бүрэлдэхүүн хэсэг 1	-	-	-
		Бүрэлдэхүүн хэсэг 2	33,800.00	30,480.00	90.2
		Бүрэлдэхүүн хэсэг 3	1,380.00	1,350.00	97.8
		Бүрэлдэхүүн хэсэг 4	-	-	-
		Бүрэлдэхүүн хэсэг 5	92.6	92.3	99.7
		Бүрэлдэхүүн хэсэг 6	337.30	299.00	88.6
		Удирдлага			
	Нийт	35,609.9	32,221.30	90.5	
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ			
	1-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 10-11 дүгээр хуудас.			
	2-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 12-17 дугаар хуудас.			
	3-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 17-23 дугаар хуудас.			
	4-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 23-26 дугаар хуудас.			
	5-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 26-30 дугаар хуудас.			
	6-р зорилтын хүрээнд:	Үнэлгээний тайлангийн 30-34 дүгээр хуудас.			
		<p>ДҮГНЭЛТ.</p> <p>1. Хөтөлбөрийн төлөвлөгөөнд нийт 99 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсанаас 2020 оны жилийн эцсийн хэрэгжилтийн үнэлгээ 90.7 хувь, хөтөлбөрийн явцын хэрэгжилт 82.3 хувьтай байна.</p> <p>2. Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн 2019 оны хэрэгжилтийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • 3.4.3.1. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорноговь аймгийн Замын-Үүд боомтод мал эмнэлгийн хяналтын цэг, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн байгууламж байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, бодис урвалжаар хангах; • 3.4.3.2. Өмнөговь, Хөвсгөл аймгийн хилийн боомтод мал эмнэлгийн хяналтын цэг, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн байгууламж байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, бодис урвалжаар хангах; • 3.4.3.3. Сүхбаатар, Дорнод аймгийн хилийн боомтод мал эмнэлгийн хяналтын цэг, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн байгууламж байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, бодис урвалжаар хангах; <p>3. Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн 3.2.2, 3.2.4, 3.3.1 дэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөлт, бодлого тодорхой биш байна.</p> <p>4. Дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандан судалгаа, лабораторийн шинжилгээний аргаар үнэлж хянах зорилтын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн боловч үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд заасан түвшин хангагдахгүй байна.</p>			

7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	ЗӨВЛӨМЖ. 1. Хөтөлбөрийн төлөвлөгөөний 72 (3.4.3.1), 73 (3.4.3.2), 74 (3.4.3.3) дугаартай арга хэмжээ нь МХЕГ-ын чиг үүрэгт хамаарах тул Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А-11 дүгээр тушаалын 3.4.3.1, 3.4.3.2, 3.4.3.3 дахь арга хэмжээг 2021 оны эхний хагас жилд багтаан Мал эмнэлгийн салбарын чиг үүрэгт хамаарах бусад арга хэмжээ тусгаж, өөрчлөн батлуулахыг, 2. Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөний 3.2.2, 3.2.4, 3.3.1 дэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний төлөвлөлтийг 2021 оны эхний хагас жилд багтаан тодорхой болгож, хэрэгжилтийг хангаж ажиллахыг, 3. Дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандан судалгаа, лабораторийн шинжилгээний аргаар үнэлж хянах зорилтын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээний үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд үндэслэн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх, тэдгээрт үндэслэн хариуцлага тооцох зэргээр төлөвлөсөн үр дүнд хүргэх чиглэлд анхаарч ажиллахыг тус тус Мал эмнэлгийн ерөнхий газарт зөвлөмжилж байна.							
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Хангалттай							
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ) Төсөл хэрэгжиж эхэлснээс хойших үнэлгээгээр	Биелэлт дундаж	Зорилгы н тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5	Зорилт 6
		82.3	6	85.9	80.7	84.4	71.7	85.7	99.3
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ							
		... %							

ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА.

Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.32 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 12 дугаар тогтоолоор “Малын эрүүл мэнд” хөтөлбөрийг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А-11 дүгээр тушаалаар “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус баталсан.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО.

Арга хэмжээний гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй харьцуулан тогтоож, тэдгээрийн хоорондын зөрүүг илрүүлэн дүн шинжилгээ хийж шалтгааныг тодруулах, түүнд үндэслэн зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 2020 оны жилийн эцсийн тайланг судлах, тухайн ажлыг хариуцсан албан

тушаалтантай ярилцах, холбогдох газраас тодруулга авах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв.

Хөтөлбөрийн зорилго. Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчин гарах, тархах шалтгаан нөхцөлийг хязгаарлан эрүүлжүүлэх арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлж, халдварт өвчингүй тайван байдлаа дотооддоо болон гадаад оронд баталгаажуулан хадгалж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэхэд оршино.

Хөтөлбөрийн зорилт.

1. Мал эмнэлгийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
2. Мал, амьтны гоц халдварт болон халдварт, шинэ болон дахин сэргэж байгаа өвчнийг эрт илрүүлэх тандалтыг өргөжүүлэх замаар өвчнийг хяналтад авч, халдварт өвчингүй тайван байдлыг лабораторийн шинжилгээний үр дүнг харгалзан бүс нутгаар баталгаажуулах;
3. Мал, амьтны гоц халдварт, зооноз, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг шинжлэх ухааны нотолгоо, тархвар зүйн судалгааг үндэслэн төлөвлөх замаар бүс нутгаар нь хяналтад авах;
4. Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар гоц халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох;
5. Мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтэн, малын эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;
6. Малчин, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг мал, амьтны эрүүл мэнд, түүнтэй шууд холбогдох нийтийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээллээр хангаж, үр дүнг сурталчлан таниулах.

Хүлээгдэж буй үр дүн

Зорилт 1. Нийт 92 журам, заавар батлуулсан байна.

Зорилт 2. Халдварт өвчингүй статустай газар нутгийн хэмжээг 10 хувьд хүргэх.

Зорилт 3. Гоц халдварт өвчний дархлаажуулалт хийж байгаа аймгийн тоо шүлхий -3, бог малын мялзан -0, хонь, ямааны цэцэг-0 болгох.

Зорилт 4. Мал эмнэлгийн хяналтын цэгээр дамжин өнгөрсөн мал, тээврийн хэрэгслийн тоо буурах.


Зорилт 5. Сургалтад хамрагдсан малын эмч, мэргэжилтний тоо 2700-д хүргэх.

Зорилт 6. Сургалтад хамруулсан малчин, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчийн тоог 35000-д хүргэх.

Хэрэгжих хугацаа. **Хөтөлбөр нь 2018-2021 онд буюу 4 жилийн хугацаанд хэрэгжинэ.**

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ. Хөтөлбөрийн төлөвлөгөөний 2020 оны хэрэгжилтийн үнэлгээ 90.7, үндэсний хөтөлбөрийн явцын хэрэгжилт 82.3 хувьтай байна. (График 1, Хүснэгт 1)


График 1



Малын эрүүл мэнд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, 2018-2020 он, зорилт тус бүрээр

Зорилт	2018 оны биелэлт	2019 оны биелэлт	2020 оны биелэлт	Хэрэгжилтийн дундаж
Зорилт 1	81.7	78.6	97.5	85.9
Зорилт 2	63.3	90.6	88.3	80.7
Зорилт 3	70.0	88.8	94.5	84.4
Зорилт 4	-	65.6	77.8	71.7
Зорилт 5	-	83.9	87.5	85.7
Зорилт 6	-	100.0	98.6	99.3
Дүн	71.7	84.6	90.7	82.3

Малын эрүүл мэнд хөтөлбөрийн төлөвлөгөөний 2020 оны хэрэгжилтийн үнэлгээ, арга хэмжээний тоогоор (График 2)



**МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ**

2020 оны жилийн эцэс

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
1	3.1.2. Мал эмнэлэг, ариун цэвэр, оношилгооны лабораториудыг сүлжээгээр ажиллах журам, бүсчлэн хөгжүүлэх чиглэлийг шинээр боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх;	3.1.2.1. Улсын мал эмнэлгийн лаборатори болон Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторид эцсийн онош тогтоох мал, амьтны халдварт өвчний жагсаалтыг боловсруулж батлуулах;	2019 - 2020		Жагсаалт батлагдсан байна.	Улс, аймаг, нийслэл, сум дүүргийн мал эмнэлгийн лабораторид эцсийн онош тогтоо мал, амьтны халдварт өвчний жагсаалтын төсөлд холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийн саналыг тусган, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/55 дугаар тушаалаар батлуулан УМЭАЦТЛ болон аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт цахимаар хүргүүлэв.	100.0
2		3.1.2.2. Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журмыг боловсруулж батлуулах;	2019 - 2020		Журам батлагдсан байна.	Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журмыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А-303 дугаар тушаалаар батлуулан эрхзүйн мэдээллийн нэгдсэн систем (legalinfo.mn)-д бүртгүүлсэн. https://www.legalinfo.mn/law/details/15637?lawid=15637	100.0
3		3.1.2.3. Мал эмнэлгийн үндэсний лавлагаа лабораторийг сонгох журмыг боловсруулж батлуулах;	2019 - 2020		Журам батлагдсан байна.	Мал эмнэлгийн үндэсний лавлагаа лабораторийг сонгох журмыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А-324 дүгээр тушаалаар батлуулан эрхзүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгүүлсэн. https://www.legalinfo.mn/law/details/15654?lawid=15654	100.0
4		3.1.2.4. Мал эмнэлгийн лабораторийг хөгжүүлэх стратегийн баримт бичгийг боловсруулж батлуулах;	2019 - 2020		Стратеги батлагдсан байна.	Мал эмнэлгийн лабораторийг хөгжүүлэх стратегийн баримт бичгийн төслийг боловсруулан, УМЭАЦТЛ болон аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторийн эрхлэгч нараас санал авч байна.	90.0
5	3.1.5. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд мөрдөх журам, стандартуудыг боловсруулж мөрдүүлэх.	3.1.5.1. Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журмыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2020		Журам батлагдсан байна.	ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А-457 дугаар тушаалаар Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журмыг баталсан. Аймаг, нийслэлийн түвшинд мал эмнэлгийн арга хэмжээг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих тухай Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны 03 тоот удирдамжийг орон нутгийн мал эмнэлгийн байгууллагуудад хүргүүлэн биелэлтийг дүгнэж ажилласан. Мал эмнэлгийн нэгдсэн системд бүртгэгдсэн 1172 үйлчилгээний нэгжээс зөрчилтэй 85 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг системээс хасаж, стандартын хэрэгжилтийг 30 асуумжаар дүгнэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	100.0
6		3.1.5.2. Төгсөлтийн дараахь үргэлжилсэн сургалт явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах журмыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2020			Төгсөлтийн дараахь үргэлжилсэн сургалт явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах журмыг ХХААХҮ-ийн Сайдын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/385 дугаар тушаалаар баталсан.	100.0

7		3.1.5.3. Малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох журмыг шинэчлэн боловсруулан батлуулах;	2018 - 2020			ХХААХҮ-ийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн А/323 дугаар тушаалаар “Малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох журам”, “Мэргэшлийн зэргийн үнэмлэх”-ийн болон “Зөвлөх малын эмчийн энгэрийн тэмдэг”-ийн загварыг тус тус баталж, 2020 оны 4890 дугаарт улсын бүртгэлд бүртгүүлэн хуулийн нэгдсэн сайтад нийтлүүлдэг байна.	100.0
8		3.1.5.4. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативыг шинээр боловсруулан батлуулах;	2018 - 2020		Норматив батлагдсан байна.	Мал эмнэлгийн ерөнхий газраас 2020 оны 3 дугаар сард Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын норматив тогтоох судалгааны ажлыг гавьяат эдийн засагч Р.Батжаргалаар ахлуулсан “Дөрвөн түшээ” ХХК-ийн эдийн засгийн судалгааны баг гүйцэтгэсэн. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын тушаалаар ХХААХҮЯ, Мал эмнэлгийн ерөнхий газар, МоҮМЭХ, УМЭАЦТЛ, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, сум, дүүргийн Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүдийг оролцуулсан ажлын хэсгийг байгуулан мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, зураглал гаргахад дэмжлэг үзүүлсэн. Холбогдох хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2.3 дахь хэсэгт заасны дагуу мал, амьтанд эмнэл зүйн үзлэг хийх, тарилга хийх /дархлаажуулалт/, халдваргүйтгэл хийх, лабораторийн шинжилгээнд зориулан сорьц авах, дуудлага үйлчилгээ үзүүлэх зардлын нормативыг тогтоон, ажлын тайланг 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга хүлээн авсан. Тайланг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлаар 1 удаа хэлэлцүүлж, ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн хуралдаанд 2020 оны 5 дугаар сарын 19-ний өдөр танилцуулж, дэмжигдсэн. Улмаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалын төсөлд Ч.Улаан сайд гарын үсэг зурж, 2020 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 01/1980 тоот албан бичгээр Сангийн сайд Ч.Хүрэлбаатарг хүргүүлсэн. Сангийн яамнаас хариу хүлээгдэж байна.	90.0
ЗОРИЛТ 1							97.5
9	3.2.1. Мал эмнэлгийн салбарын мэдээллийн нэгдсэн цахим сүлжээг бий болгох;	Мал, малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн гарал үүсэл, чанар, аюулгүй байдлыг мөшгөн тогтоох нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бий болгон ажиллуулах	2019-2020		Цахим бүртгэлийн сантай болсон байна.	Мал эмнэлгийн салбарт цахим технологи нэвтрүүлж аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, сум, дүүрэг дэх мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн түвшинд мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, ариун цэвэр, эрүүл ахуйг баталгаажуулах, мал эмнэлгийн урьчилан сэргийлэх арга хэмжээг малчин өрх нэг бүрээр цахимаар төлөвлөж, гүйцэтгэлд хяналтыг хэрэгжүүлж байна. Ингэснээр Мал, амьтны элдэв өвчний гаралтын мэдээллийг Үндэсний дата төвд байрлах серверт бүртгэж, архив үүсгэж өвчний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлсэн. Мал эмнэлгийн тасгийн төлөвлөсөн халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх бүхий л арга хэмжээг хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч гар утасны аппликейшн ашиглан гүйцэтгэлийг малчин өрхийн хотноос оруулж, малчин, малын эмчийн хуулиар хүлээсэн үүргийг биелэлтийг бүрэн хянадаг болсон. Нэгдсэн цахим систем нэвтэрснээр эрүүл мал сүрэгтэй малчин өрх, баг, сум, аймгийг баталгаажуулах боломж бүрдсэн. Эрүүл мал сүрэгтэй малчин өрхөөс бэлтгэсэн мах, сүүг үйлчилгээ үзүүлдэг малын эмч баталгаажуулж эцсийн хэрэглэгч хүртэл гарал үүсэл тодорхой байж хүнсний аюулгүй байдлыг хангуулж байна. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 978 мал эмнэлгийн үйлчилгээний нэгж 2020 онд нийт 476857 ширхэг мал эмнэлгийн гэрчилгээг цахимаар олгож, 2124 тонн цагаан идээ, 21140 тонн сүү, 161 тонн тараг, 136288 тонн мах, 1529 тонн дайвар бүтээгдэхүүн, 73 сая ширхэг өндөг, 4 сая 073 ширхэг арьс, 5059 тонн	100.0

					ноолуур, 228361 тонн ноосонд мал эмнэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн баталгаажуулалт хийж хэрэглэгчид нийлүүлсэн байна. Малын шилжилт хөдөлгөөний хяналтыг мал эмнэлгийн нэгдсэн системээр хянах боломж бүрдүүлэн ашиглаж байна. Мал эмнэлгийн цахим гэрчилгээг амьд малд олгохдоо тухай малын зургийг оруулж баталгаажуулснаар шилжилт хөдөлгөөний хяналт сайжирч, малын хулгайн гэмт хэрэг өмнөх оныхоос 27,8 хувиар буурсан.		
10		3.2.1.3. Мал, амьтны гоц халдварт, халдварт, шинэ болон дахин сэргэж буй өвчнийг эрт илрүүлэх тандалтын нэгдсэн цахим бүртгэлийг сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын мал эмнэлгийн байгууллагуудад нэвтрүүлэх;	2019 - 2020		Мал эмнэлгийн ерөнхий газар, Швейцарын элчин сайдын яамны хамтын ажиллагааны газартай байгуулсан гэрээний хүрээнд Ногоон алт-Малын эрүүл мэнд төсөл, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/167 дугаар тушаал болон малын эрүүл мэндийн нэгдсэн системийг Монгол улсын 21 аймаг, нийслэлд нэвтрүүлсэн. Мал эмнэлгийн нэгдсэн систем нэвтэрснээр аймаг, нийслэлийн мал эмнэлгүүд урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлт, халдварт, гоц халдварт, шимэгчтгэх, халдваргүй өвчний дуудлага болон өвчлөлийг бүртгэснээр малын өвчний мэдээллийн сан бий болж байна. 2020 онд нийт 15587 дуудлага бүртгэгдсэн байна. 2020 онд хэрэгжүүлсэн гоц халдварт, халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг Мал эмнэлгийн нэгдсэн цахим системд оруулсныг хянан үйлчилгээний хөлсийг олгох ажлыг эхлүүлээд байна.	100.0	
11	3.2.2. Бүсийн оношилгоо, шинжилгээний лабораторийг зүүн, хангайн, баруун бүсэд өргөтгөн байгуулж,	3.2.2.1. Баруун бүсэд мал эмнэлгийн лабораторийг өргөтгөн бүсийн лаборатори байгуулах	2020 - 2021		3 бүсэд лаборатори байгуулагдсан байна.	Баруун бүсэд мал эмнэлгийн лабораторийг өргөтгөн бүсийн лабораторийг Ховд аймагт байгуулах ажлыг “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөн, урьдчилсан бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.	70.0
12	дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлэх;	3.2.2.2. Хангайн бүсэд мал эмнэлгийн лабораторийг өргөтгөн бүсийн лаборатори байгуулах;	2020 - 2021			Төвийн бүсэд мал эмнэлгийн лабораторийг өргөтгөн бүсийн лабораторийг Булган аймагт байгуулах ажлыг “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөн, урьдчилсан бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.	70.0
13		3.2.2.3. Зүүн бүсэд мал эмнэлгийн лабораторийг өргөтгөн бүсийн лаборатори байгуулах;	2020 - 2021			Зүүн бүсэд мал эмнэлгийн лабораторийг өргөтгөн бүсийн лабораторийг Хэнтий аймагт байгуулах ажлыг “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөн, урьдчилсан бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.	70.0
14	3.2.3. Төв, орон нутгийн мал эмнэлэг, ариун цэвэр, оношилгооны лабораторийн барилга, тоног төхөөрөмжийг бүрэн шинэчлэх, лабораториудад шаардлагатай эм, урвалж, оношлуур, тоног төхөөрөмжийн нөхөн хангалт	3.2.3.1. Мал эмнэлгийн лабораторийн барилгыг шинээр болон шинэчлэн барих, тоног төхөөрөмжөөр хангах, засвар үйлчилгээг хийх арга хэмжээг зохион байгуулах;	2019 - 2021		Лабораторийн тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангасан байна	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн хуучин барилгын их засврын ажлыг 402,164.8 төгрөг, тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг 360,0 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн. Өмнөговь аймагт 774,0 сая, Архангай аймагт 1,0 тэрбум төгрөгийн санхүүжилттэй Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн барилгын ажлыг ХХААХҮЯ, тухайн тойргийн УИХ-ын гишүүд, орон нутгийн санхүүжилтээр барьж, иж бүрэн мал эмнэлгийн байрыг ашиглалтад хүлээн авсан. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй төслийн хүрээнд Дорноговь аймгийн Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн барилгын ажлын гүйцэтгэл 80 хувьтай, Сэлэнгэ аймгийн Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн барилгын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.	100.0
15		3.2.3.2. Мал эмнэлгийн лабораториудад шаардлагатай эм, урвалж, оношлуурын	2019 - 2021		Өвчнийг эрт илрүүлэх нөхцөл	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 2020 онд худалдан авах ажиллагаагаар нийлүүлэгдэх барааг нийт 6 тендерээр (Гоц халдварт шүлхий өвчний оношлуур, урвалж худалдан авах МЭТШ/2020/03-012, Мал амьтны халдварт, гоц халдварт өвчний оношлуур, эм урвалж, шил сав худалдан авах	90.0

	хийх, зохих нөөцийг бүрдүүлж бэлэн байдлыг хангах;	хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах;			хангагдсан байна.	МЭТШ/2020/03-014/1, МЭТШ/2020/03-014/2, МЭТШ/2020/03-014/3, Бог малын мялзан, гахайн африкийн мялзан өвчний оношлуур, хэрэглэгдэхүүн худалдан авах МЭТШ/2020/03 -013, Бруцеллэз өвчнийг эрүүлжүүлэх шинжилгээнд шаардагдах хэрэглэгдэхүүн, багаж хэрэгсэл худалдан авах МЭТШ/2020/03-011) шалгаруулан УМЭАЦТЛ болон аймаг, нийслэлийн лабораториудад нийлүүлсэн.	
16		3.2.3.3. Гоц халдварт, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнийг оношлох оношлуурын нөөцийг орон нутгийн түвшинд бүрдүүлж, ашиглалтыг сайжруулах;	2019 - 2021			Шүлхийгээс сэргийлэх вакциныг ОХУ-ын үйлдвэрлэгчээс нийт 12,0 сая тун, бог малын мялзангаас сэргийлэх вакциныг Энэтхэг улсын үйлдвэрлэгчээс 3,0 сая тун, хонины цэцгээс сэргийлэх вакциныг Биокомбинат УТҮГ-аас 3,0 сая тун, гоц халдварт бог малын мялзангаас сэргийлэх вакцины шингэлэгч 8,0 мянган литрийг АйВиКо ХХК, мал амьтны халдварт, гоц халдварт өвчний оношлуур, эм урвалж, шил сав худалдан авах тендерийн 1-р багцад Монветмед ХХК, 2-р багцад Монголиан прайвет ветеринарий дундын хоршоо, 3-р багцад Гарааны ветбиотех ХХК, Шүлхий өвчний оношлуур хэрэглэгдэхүүнийг нийлүүлэх, Бог малын мялзан өвчний оношлуур, хэрэглэгдэхүүн нийлүүлэх тендерт Монветмед ХХК, Бруцеллэз өвчнийг эрүүлжүүлэх шинжилгээнд шаардагдах хэрэглэгдэхүүн, багаж хэрэгсэл худалдан авах тендерт Глобал бизнеслинк ХХК шалгарсны дагуу гэрээ байгуулж, хүлээн авсан барааг орон нутагт баталсан хуваарийн дагуу хүргэсэн. Сүүлийн жилүүдэд мал эмнэлгийн салбарт ашиглагдаж байгаа зарим оношлуурыг дотоодын үйлдвэрлэгчээс худалдан авах ажлыг зохион байгуулснаар бага зардлаар чанартай, тооны хувьд хангалттай олон төрлийн оношлуурыг худалдан авах ажлыг хэрэгжүүлж эхлээд байна. Тухайлбал: 2020 онд 108 сая төгрөгөөр Мал эмнэлгийн хүрээлэн болон бусад дотоодын оношлуур үйлдвэрлэгчээс худалдан авч аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт нийлүүлсэн нь хэрэгцээ, хангамжийг нэмэгдүүлэхэд дөхөм болсон ажил байлаа.	90.0
17	3.2.4. Шинжлэх ухааны тооцоо, судалгаанд	3.2.4.1. Тархвар зүйн судалгааны хуудасны загвар, судалгаа хийх төлөвлөгөөг боловсруулан батлуулах;	2019 - 2020		Төлөвлөгөөг батлуулсан байна.	Тархварзүйн судалгаа хийх төлөвлөгөө, судалгааны загвар хуудсыг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 10 сарын 21-ний өдрийн А/187 дугаар тушаалаар баталсан.	100.0
18	тулгуурласан тандалт судалгааг хийх загварыг сум, аймаг, бүсийн түвшинд боловсруулж, хэрэгжүүлэх, үр дүнг нэгтгэх, тандалт, шинжилгээний ажлын эдийн засгийн үр ашгийг тооцох;	3.2.4.2. Баруун бүсийн 2 аймагт гоц халдварт, халдварт өвчний тандалтын загварыг боловсруулж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцох;	2019 - 2020		6 аймагт загвар боловсруулж, үр дүнг тооцсон байна.	Баруун бүсэд гоц халдварт, халдварт өвчний тандалт хийх загвар боловсруулах, хэрэгжилтийг хангах, үр дүнг тооцох ажлыг “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөн, урьдчилсан бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. Төслийн хүрээнд Мал эмнэлгийн салбарт хэрэгжүүлж байгаа тандалтад олон улсын стандарт аргачлалын дагуу үнэлгээ хийж, гарсан үр дүнд тулгуурлан тандалтын ажлын зорилго, аргачлал, үр дүнг үнэлэхэд баримтлах зөвлөмж, чиглэлийг боловсруулах ажил хийгдэж байна.	70.0
19		3.2.4.3. Хангайн бүсийн 2 аймагт гоц халдварт, халдварт өвчний тандалтын загварыг боловсруулж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцох;	2019 - 2020			Хангайн бүсэд гоц халдварт, халдварт өвчний тандалт хийх загвар боловсруулах, хэрэгжилтийг хангах, үр дүнг тооцох ажлыг “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөн, урьдчилсан бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. Төслийн хүрээнд Мал эмнэлгийн салбарт хэрэгжүүлж байгаа тандалтад олон улсын стандарт аргачлалын дагуу үнэлгээ хийж, гарсан үр дүнд тулгуурлан тандалтын ажлын зорилго, аргачлал, үр дүнг үнэлэхэд баримтлах зөвлөмж, чиглэлийг боловсруулах ажил хийгдэж байна.	70.0

20		3.2.4.4. Зүүн бүсийн 2 аймагт гоц халдварт, халдварт өвчний тандалтын загварыг боловсруулж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцох;	2019 - 2020			Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд мал эмнэлгийн салбарт хэрэгжүүлж байгаа тандалтад олон улсын стандарт аргачлалын дагуу үнэлгээ хийж, гарсан үр дүнд тулгуурлан тандалтын ажлын зорилго, аргачлал, үр дүнг үнэлэхэд баримтлах зөвлөмж, чиглэлийг боловсруулах ажил хийгдэж байна.	70.0
21	3.2.5. Сум, аймаг, бүсийн түвшинд олон улсын худалдаанд саад тотгор учруулдаг, хүнсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа зарим өвчин (бруцеллез, сүрьеэ, шүлхий, бог малын мязан)-өөс эрүүлжсэн болох талаар олон улсын жишигт нийцүүлэн баталгаажуулан мэдээлэх;	3.2.5.1. Шүлхий өвчийг эрт илрүүлэх тандалт шинжилгээ, дархлаажуулалтын дараахь мониторингийг төвийн бүсийн 7000, баруун бүсийн 7000 малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах;	2018 - 2021		Шүлхий, бог малын өвчнөөр тайван бүс нутгийн хэмжээг нэмэгдүүлж, өвчнөөр тайван статусыг хадгална.	Гоц халдварт шүлхий өвчний халдвар илрүүлэх тандалтыг улсын хэмжээнд бүх аймгийг хамруулан нэгэн зэрэг явуулсан бөгөөд баруун, төвийн, зүүн гэсэн 3 бүсээр хуваан нийт 13,170 толгой мал сүргийг тархвар зүйн судалгаанд үндэслэн хамруулсан. Баруун бүсийн 7 аймагт хийсэн шүлхийн өргөн хүрээтэй тандалт шинжилгээний үр дүнд шүлхий өвчний бүтцийн бус уургийн эсрэгбиом илрүүлэх болон молекул биологийн шинжилгээгээр эерэг сорьц бүртгэгдээгүй, Төвийн бүсийн 10 аймагт хийсэн баталгаажуулах шинжилгээний үр дүнд Нийслэлийн 6 сорьцод бүтцийн бус уургийн эсрэг биом илэрсэн. Улсын хэмжээнд УМЭАЦТЛ-ийн баталгаажуулах шинжилгээгээр 122 сорьцын эерэг үр дүнг баталгаажуулснаар улсын хэмжээнд шүлхийн 0.93%-ийн халдварлалттай байна. Шүлхийн вакцины дараахь мониторингийн тандалтыг ОХУ-ын тосон хүчлүүрт шүлхийн О, А хэвшлийн вакцин таригдсан мал сүргээс нийт 9 аймгийн 22 сумын 330 малчин өрхийн 4950 малд хийсэн. О хэвшилд 3833 эерэг буюу дархлаажилт 77.4%-тай, А хэвшилд 3967 эерэг буюу дархлаажилт 80.1%-тай байна.	100.0
22		3.2.5.2. Бог малын мязан өвчнийг эрт илрүүлэх шинжилгээ, дархлаажуулалтын дараахь мониторингийг баруун болон зүүн бүсийн 5 аймгийн 10000 мянан малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах	2018 - 2021			Бог малын мязан өвчний халдвар илрүүлэх тандалт шинжилгээгээр 2020 онд нийт 3080 хонь, ямааны сорьцыг шинжлэхэд бог малын мязан өвчний халдвар илрээгүй. Бог малын мязан өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын дараахь мониторингийн тандалтаар Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр аймгийн 18 сум, 28 багийн 180 малчин өрхөөс нийт 4992 толгой малаас сорьц цуглуулсан. Хэнтий аймагт 3 сумын нийт 1092 сорьцноос 850 (78%), Дорнод аймгийн 3 сумын нийт 1092 сорьцноос 684 (63%), Сүхбаатар аймгийн 3 сумын нийт 1092 сорьцноос 404 (37%), Дорноговь аймгийн 3 сумын нийт 1092 сорьцноос 833 (76%), Говьсүмбэр аймгийн 2 сумын нийт 624 сорьцноос 217 (35%) сорьц тус тус эерэг урвал үзүүлж, улсын хэмжээнд дархлаажуулалтын ажил 59.86 хувийн гүйцэтгэлтэй явагдсан байна. Дархлаажуулалтын дараахь мониторингийн үр дүнд үндэслэн аймаг тус бүрээр цаашид анхаарах асуудал, хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж боловсруулан дээрх аймгуудын Мал эмнэлгийн газарт хүргүүлээд байна.	100.0
23		3.2.5.3. Үхрийн сүрьеэ өвчнийг тандах шинжилгээг баруун бүсийн 5 аймгийн 10000 мянган малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах;	2018 - 2021		Үхрийн сүрьеэ, бруцеллэз өвчнөөс эрүүл болохыг тогтоосон байна.	Үхрийн сүрьеэ өвчний тандалтаар 8 аймгийн 7597 сорьцыг харшил сорилоор шинжилсэн бөгөөд 100 хувь сөрөг үр дүнтэй байна.	90.0
24		3.2.5.4. Бруцеллэз өвчнийг тандах шинжилгээг баруун бүсийн 5 аймгийн 10000 мянган малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах;	2018 - 2021			Бруцеллэз өвчнөөс эрүүлийг баталгаажуулах шинжилгээнд 2020 онд 20 аймаг, нийслэлийн А дансанд бүртгэгдсэн нийт 377,953 толгой хээлтүүлэгч малыг хамруулахаар төлөвлөсөн боловч төсөвлөсөн зардал хасагдсантай холбогдуулан 286,800 толгой мал хамруулсан нь тандалтын гүйцэтгэлийг 69,4% хүртэл бууруулсан. УМЭАЦТЛ-г хийсэн баталгаажуулах шинжилгээгээр 496 сорьцын эерэг урвалыг ХХУ болон бактериологи, молекул биологийн аргаар шинжлэхэд	100.0

					улсын хэмжээнд малын бруцеллэзын 0.019%-ийн халдварлалт (буур-0.0%, бух-0.2%, хуц-0.2%, ухна-0.1%)-тай гарсан байна.	
25		3.2.5.5. Үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүлийг баталгаажуулах арга хэмжээг зохион байгуулах	2018 - 2021	ДМАЭМБ-аас 2 өвчнөөс эрүүл болохыг баталгаажуулсан байна.	Үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүлийг баталгаажуулах шинжилгээг Мал эмнэлгийн ерөнхий газрын захиалгаар Мал эмнэлгийн хүрээлэнгийн судалгааны баг 2020 онд гүйцэтгэсэн. Нийслэл болон 21 аймгаас цуглуулсан Үхрийн цээж өвчнийг илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээгээр 9550 сорьцноос 5 аймагт хамаарах 17 (0.17%), Ямааны годрон өвчнийг илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээгээр 6286 сорьцноос 13 аймагт хамаарах 34 (0.54%) сорьц тус тус эерэг урвал үзүүлсэн байна.	100.0
26		3.2.5.6. Зарим гоц болон архаг халдварт өвчнийг сум, аймгийн түвшинд баталгаажуулан мэдээллэх;	2018 - 2021	Нийт нутаг дэвсгэрийн 10 хувийг зарим гоц халдварт, архаг халдварт өвчнөөр эрүүл болохыг баталгаажуулсан байна.	Гахайд зонхилон тохиолддог халдварт өвчнүүдийн халдварлалтын түвшинг тогтоох, халдварт өвчнийг эрт илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх шинжилгээний дүнгээр: Гахайн сонгомол мялзан өвчний эсрэгбиом 111 (25%), гахайн парвовирусын эсрэгбиом 94 (21%), гахайн цирковироз 203 (46%), гахайн уушгины микоплазм 46 (10%) сорьцод тус тус илэрсэн бол Гахайн африкийн мялзан, гахайн томуу, гахайн үржил амьсгалын замын хам шинж, корановирус, ходоод гэдэсний хам үрэвсэл, шүлхий, лептоспироз, бруцеллэз өвчний эсрэгбиом илрээгүй буюу тухайн өвчний халдвар байхгүй болохыг тогтоосон. Үхрийн тархи сархиагтах өвчний тандалт шинжилгээг ДМАЭМБ-аас зөвлөсөн аргачлалын дагуу Сэлэнгэ, Хөвсгөл, Архангай, Завхан, Өвөрхангай, Булган аймгийн нядалгааны газраас нийт 270 тархины сорьцод ЭЛИЗА урвалын хариу 100% сөрөг байна. 2020 онд мал эмнэлгийн гоц халдварт болон халдварт өвчний тандалт шинжилгээнд улсын хэмжээнд нийт 333,212 толгой мал хамруулан 78,6%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн. Хээлтүүлэгч малын бруцеллэзын шинжилгээнд 325 сум, дүүргийн 1,236 баг, 55,053 өрх аймаас 262,509 сорьц авч, 91.5%-тай хэрэгжсэн. РБУ-аар нийт эерэг 262,509 мал шинжилснээс 496 буюу 0.19%-д эсрэг биом илэрсэн байна. Нийслэл болон 21 аймгийн Үхрийн цээж өвчнийг илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээнд хамруулсан 9550, Ямааны годрон өвчнийг илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээнд хамруулсан 6286 сорьцноос ямааны годрон, үхрийн цээж өвчнөөр сөрөг байна. Шүлхий өвчний шинжилгээнд 13,1 мянган сорьц шинжилснээс 122 сорьц эерэг буюу 0.93%-ийн, бог малын мялзангийн шинжшинжилгээнд 13,0 мянган сорьц шинжилснээс 0 сорьц эерэг байна.	100.0
ЗОРИЛТ 2						88.3
26	3.3.1. Бүх шатны мал эмнэлгийн байгууллагуудад вакцин, эм бэлдмэлийг хадгалах хөргүүр, хүйтэн хэлхээгээр тээвэрлэх	3.3.1.1. Зүүн бүсийн мал эмнэлгийн байгууллагуудад вакцин, биобэлдмэлийг хадгалах, зөөвөрлөх чадавхийг сайжруулах;	2020 - 2021	Вакцин, эм бэлдмэлийг хадгалах хөргүүр, хүйтэн хэлхээгээр тээвэрлэх сүлжээг бүх шатанд бүрдүүлсэн байна.	Биокомбинат УТҮГ-т 2020 онд хүйтэн хөргүүр бүхий автомашиныг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бөгөөд уг автомашинаар аймаг хүртэлх вакцин, биобэлдмэлийн тээвэрлэлтийг хийж байна. Харин аймгийн Мал эмнэлгийн газрууд бүгд вакцин, биобэлдмэл хадгалах хүйтэн хэлхээний төхөөрөмжтэй. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд нь зөөврийн хөргүүр ашиглан, вакцин биобэлдмэлийг тээвэрлэдэг.	70.0
27	хадгалах хөргүүр, хүйтэн хэлхээгээр тээвэрлэх ложистик сүлжээг байгуулах;	3.3.1.2. Хангайн бүсийн мал эмнэлгийн байгууллагуудад эм, биобэлдмэлийг хадгалах, зөөвөрлөх чадавхийг сайжруулах;	2020 - 2021		Биокомбинат УТҮГ-т 2020 онд хүйтэн хөргүүр бүхий автомашиныг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бөгөөд уг автомашинаар аймаг хүртэлх вакцин, биобэлдмэлийн тээвэрлэлтийг хийж байна. Харин аймгийн Мал эмнэлгийн газрууд бүгд вакцин, биобэлдмэл хадгалах хүйтэн хэлхээний төхөөрөмжтэй. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд нь зөөврийн хөргүүр	90.0

					ашиглан, вакцин биобэлдмэлийг тээвэрлэдэг. Зарим аймгуудад Хөдөө аж ахуйн маркетинг төслийн хүрээнд нийлүүлсэн хөргүүртэй автомашинаар сум хүртэлх вакцин биобэлдмэлийн тээвэрлэлтийг хийж хэвшээд байна.	
28		3.3.1.3. Төвийн бүсийн мал эмнэлгийн байгууллагуудад эм, биобэлдмэлийг хадгалах, зөөвөрлөх чадавхийг сайжруулах;	2020 - 2021		Биокомбинат УТҮГ-т 2020 онд хүйтэн хөргүүр бүхий автомашиныг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бөгөөд уг автомашинаар аймаг хүртэлх вакцин, биобэлдмэлийн тээвэрлэлтийг хийж байна. Харин аймгийн Мал эмнэлгийн газрууд бүгд вакцин, биобэлдмэл хадгалах хүйтэн хэлхээний төхөөрөмжтэй. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд нь зөөврийн хөргүүр ашиглан, вакцин биобэлдмэлийг тээвэрлэдэг.	70.0
29		3.3.1.4. Баруун бүсийн мал эмнэлгийн байгууллагуудад эм, биобэлдмэлийг хадгалах, зөөвөрлөх чадавхийг сайжруулах.	2020 - 2021		Биокомбинат УТҮГ-т 2020 онд хүйтэн хөргүүр бүхий автомашиныг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бөгөөд уг автомашинаар аймаг хүртэлх вакцин, биобэлдмэлийн тээвэрлэлтийг хийж байна. Харин аймгийн Мал эмнэлгийн газрууд бүгд вакцин, биобэлдмэл хадгалах хүйтэн хэлхээний төхөөрөмжтэй. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд нь зөөврийн хөргүүр ашиглан, вакцин биобэлдмэлийг тээвэрлэдэг. Зарим аймгуудад Хөдөө аж ахуйн маркетинг төслийн хүрээнд нийлүүлсэн хөргүүртэй автомашинаар сум хүртэлх вакцин биобэлдмэлийн тээвэрлэлтийг хийж хэвшээд байна.	90.0
30		3.3.2.1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг эрсдэл бүхий бүс, аймгуудад зохион байгуулах;	2019 - 2021	686.9 сая	Вакцинд хамрагдалтыг 85 хувиас доошгүйд хүргэх, өвчнөөр тайван байдлаа хадгална.	100.0
31	3.3.2. Мал, амьтны гоц халдварт, зооноз, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг тандан судалгааны үр дүнд үндэслэн төлөвлөж хэрэгжүүлэх;	3.3.2.2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг эрсдэл бүхий бүс, аймгуудад зохион байгуулах;	2019 - 2021		Шүлхийгээс сэргийлэх дархлаажуулалтад зүүн болон төвийн бүсийн хилийн боомт бүхий, өвчин гарах эрсдэлтэй 11 аймаг, нийслэлийн 19,3 сая толгой мэдрэмтгий мал сүргийг хамруулахаар төлөвлөж, дархлаажуулалтыг 2020 оны хавар 05-р сард 10 аймаг, нийслэлийн 87 сум, дүүргийн 30,1 мянган өрхийн нийт бод 1,459 сая толгой, бог 10,587 сая толгой, нийт 12,0 сая толгой, намрын дархлаажуулалтыг 10-р сард зохион байгуулж, 11 аймаг, нийслэлийн 97 сум, дүүргийн 43,5 мянган өрхийн нийт бод 1,372 сая толгой, бог 11,298 сая толгой, нийт 12,6 сая толгой мэдрэмтгий мал тус тус хамруулсан. 2020 онд нийт 11 аймаг, нийслэлийн давхардсан тоогоор 184 сумын 73,615 өрхийн нийт бод 2,842 сая толгой, бог 21,886 сая буюу нийт 24,728 сая толгой мэдрэмтгий мал хамруулж, төлөвлөснөөс 28.1 хувиар олон мал хамруулсан. Энэ зүүн аймгийн төл болон отроор өвөлжиж байгаа малын тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор төлөвлөснөөс илүү олон мал таригдсан.	100.0
32		3.3.2.3. Хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг эрсдэл бүхий бүс, аймгуудад зохион байгуулах;	2019 - 2021	414.4 сая	Өвчнөөр тайван байдлаа хадгална.	100.0
33		3.3.2.4. Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх	2019 - 2021	2,260.0 сая	Бодыг 60-иас, богийг	100.0

		дархлаажуулалтыг зохион байгуулах;			70 хувиас доошгүй дархлаа тогтоон, өвчнөөр тайван байдлаа хадгална	эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А/43 дугаар тушаалаар баталсан 2020 оны дархлаажуулалтын төлөвлөгөөний дагуу Биокомбинат УТҮГ-аас вакциныг орон нутагт нийлүүлсэн. Дархлаажуулалтад 14.8 сая толгой төл хамруулж, 95.6%-тай хэрэгжсэн байна. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Засгийн газрын 225 дугаар тогтоолын дагуу нийт 2.26 тэрбум төгрөгийн үйлчилгээний хөлсийг 20 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газраар дамжуулан мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд олгосон байна.	
34		3.3.2.5. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 18 нэрийн өвчний дархлаажуулалтыг голomt бүхий бүсүүдэд зохион байгуулах;	2019 - 2021	1,400.0 сая	Халдварт өвчин бүртгэгдсэн бүс, аймаг, сумын тоог бууруулсан байна.	Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын дэргэдэх Мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн хурлаар төлөвлөгөөг хэлэлцүүлж, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А/43 дугаар тушаалаар 2020 оны дархлаажуулалтын төлөвлөгөө баталсан. Улсаас санхүүжүүлэх дархлаажуулалтын 7 нэрийн вакцинд 8.0 сая толгой мал, амьтан, орон нутгаас санхүүжүүлэх дархлаажуулалтын 9 нэрийн вакцинд 11.8 сая толгой мал, амьтан, иргэн, хуулийн этгээдээс санхүүжүүлэх дархлаажуулалтын 3 нэрийн вакцинд 4.9 сая толгой мал, амьтан, нийт 19 нэрийн өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад давхардсан тоогоор 24.7 сая толгой мал, амьтан хамруулахаар төлөвлөж, Биокомбинат УТҮГ-тай гэрээ байгуулсан. 2020 оны жилийн эцсийн мэдээгээр 24.38 сая толгой мал, амьтан хамруулж, 96.7%-тай гүйцэтгэл хийгдсэн байна. Жил бүр халдварт, зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг тогтмол гүйцэтгэснээр өмнөх оноос өвчилсэн мал, амьтны тоо 8687 толгой, үхсэн мал, амьтны тоо 1654 толгойгоор тус тус буурсан байна. боом, галзуу, адууны томуу, листериоз, гахайн сонгомол мялзан, шувууны тахал гэсэн 6 вакцины дархлаажуулалтын үйлчилгээний хөлсөнд 1.4 тэрбум төгрөгийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид улсын төсвөөс олгосон байна.	100.0
35	3.3.3. Дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандан судалгаа, лабораторийн шинжилгээний аргаар үнэлэж хянах;	3.3.3.1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандалт (лабораторийн шинжилгээ)-ын аргаар хийх;	2018 - 2021		85 хувиас доошгүй дархлаа тогтсоныг баталгаажуулна.	Бог малын мялзан өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын дараахь мониторингийн тандалтад Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр аймгийн 18 сум, 28 багийн 180 малчин өрхөөс 4992 толгой малаас сорьц авч шинжилсэн. Хэнтий аймагт 3 сумын нийт 1092 сорьцноос 850 (78%), Дорнод аймгийн 3 сумын нийт 1092 сорьцноос 684 (63%), Сүхбаатар аймгийн 3 сумын нийт 1092 сорьцноос 404 (37%), Дорноговь аймгийн 3 сумын нийт 1092 сорьцноос 833 (76%), Говьсүмбэр аймгийн 2 сумын нийт 624 сорьцноос 217 (35%) сорьц тус тус эерэг урвал үзүүлж, улсын хэмжээнд дархлаажуулалт 59.86 хувийн гүйцэтгэлтэй явагдсан байна.	90.0
36		3.3.3.2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандалт (лабораторийн шинжилгээ)-ын аргаар зохион байгуулах;	2018 - 2021			Шүлхийн вакцины дараахь мониторингийн тандалтад ОХУ-ын тосон хүчлүүрт шүлхийн О, А хэвшлийн вакцин таригдсан нийт 9 аймгийн 22 сумын 330 малчин өрхийн 4950 малд шинжилгээ хийсэн. 2020 оны 3, 5 сард вакцин тарьсан нийт 4,950 сорьцноос О хэвшилд 3833 сорьц эерэг буюу дархлаажилт 77.4%, А хэвшилд 3967 сорьц эерэг урвал буюу дархлаажилт 80.1%-тай тус хийгдсэн байна.	100.0
37		3.3.3.3. Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандалт (лабораторийн	2018 - 2021		85 хувиас доошгүй дархлаа тогтсоныг	Бруцеллэзын вакцины дараахь мониторингийн шинжилгээнд гурван бүсийн 8 аймгийн 16 сумын нийт 9280 толгой мал хамруулснаас 7866 толгой мал эерэг урвалтай буюу нийт сүргийн дархлааны хариу урвалын түвшин 84.7%-тай гарсан байна.	100.0

		шинжилгээ)-ын аргаар зохион байгуулах;			баталгаажуул на.		
38		3.3.4.1. Баруун бүсэд гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм, вакцин, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын багаж, хувцас хэрэгсэлийн нөөцийг бүрдүүлэх;	2019 - 2021			Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А/160 дугаар тушаалын дагуу тендерийн бараа, бүтээгдэхүүнийг хүлээж авах ажлын хэсэг ариутгал, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын хувцас, багаж хэрэгсэл нийлүүлэх МЭТШ/2020/03/007-І, ІІ дугаар багцын тендерт шалгарсан “Бест агро интернэйшнл” ХХК, “Тэнүүн хишиг” ХХК-ний нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүнийг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан хуваарийн дагуу орон нутагт хүргүүлсэн. Баруун бүсийн 5 аймгийн Мал эмнэлгийн газарт нийт халдваргүйтгэлийн бодис 4000 кг (хлорын шохой, суперкилл, роксицид), халдвар хамгааллын нэг удаагийн иж бүрдэл 750 ширхэг, олон удаагийн халдвар хамгааллын хувцасны иж бүрдэл 50 ширхэг, халдваргүйтгэлийн багаж болох дулаанаар мананцаржуулагч 5 ширхэг, хүйтнээр мананцаржуулагч 5 ширхэгийг тус тус холбогдох зааврын хамт хүргүүлсэн.	100.0
39	3.3.4. Мал, амьтны гоц халдварт, зооноз, халдварт өвчний эрсдлийн дүн шинжилгээнд үндэслэн шаардлагатай вакцин, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын багаж, хувцас хэрэгсэлийн нөөцийг бүрдүүлэх;	3.3.4.2. Хангайн бүсэд гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм, вакцин, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын багаж, хувцас хэрэгсэлийн нөөцийг бүрдүүлэх;	2019 - 2021		Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газруудад эм бэлдмэл, вакцины нөөц бүрдсэн байна.	Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А/160 дугаар тушаалын дагуу тендерийн бараа, бүтээгдэхүүнийг хүлээж авах ажлын хэсэг ариутгал, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын хувцас, багаж хэрэгсэл нийлүүлэх МЭТШ/2020/03/007-І, ІІ дугаар багцын тендерт шалгарсан “Бест агро интернэйшнл” ХХК, “Тэнүүн хишиг” ХХК-ний нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүнийг хуваарийн дагуу орон нутагт хүргүүлсэн. Хангайн бүсийн 6 аймгийн Мал эмнэлгийн газарт нийт халдваргүйтгэлийн бодис 5300 кг (хлорын шохой, суперкилл, роксицид), халдвар хамгааллын нэг удаагийн иж бүрдэл 900 ширхэг, олон удаагийн халдвар хамгааллын хувцасны иж бүрдэл 60 ширхэг, халдваргүйтгэлийн багаж болох дулаанаар мананцаржуулагч 6 ширхэг, хүйтнээр мананцаржуулагч 6 ширхэгийг тус тус холбогдох зааврын хамт хүргүүлсэн.	100.0
40	халдвар хамгааллын багаж, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх;	3.3.4.3. Төвийн бүсэд гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм, вакцин, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын багаж, хувцас хэрэгсэлийн нөөцийг бүрдүүлэх;	2019 - 2021			Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А/160 дугаар тушаалын дагуу тендерийн бараа, бүтээгдэхүүнийг хүлээж авах ажлын хэсэг ариутгал, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын хувцас, багаж хэрэгсэл нийлүүлэх МЭТШ/2020/03/007-І, ІІ дугаар багцын тендерт шалгарсан “Бест агро интернэйшнл” ХХК, “Тэнүүн хишиг” ХХК-ний нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүнийг хуваарийн дагуу орон нутагт хүргүүлсэн. Төвийн бүсийн 7 аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт халдваргүйтгэлийн бодис 6100 кг (хлорын шохой, суперкилл, роксицид), халдвар хамгааллын нэг удаагийн иж бүрдэл 1200 ширхэг, олон удаагийн халдвар хамгааллын хувцасны иж бүрдэл 80 ширхэг, халдваргүйтгэлийн багаж болох дулаанаар мананцаржуулагч 8 ширхэг, хүйтнээр мананцаржуулагч 8 ширхэгийг тус тус холбогдох зааврын хамт хүргүүлсэн.	100.0
41		3.3.4.4. Зүүн бүсэд гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм, вакцин, оношлуур, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын багаж, хувцас хэрэгсэлийн нөөцийг бүрдүүлэх;	2019 - 2021			Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А/160 дугаар тушаалын дагуу тендерийн бараа, бүтээгдэхүүнийг хүлээж авах ажлын хэсэг ариутгал, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын хувцас, багаж хэрэгсэл нийлүүлэх МЭТШ/2020/03/007-І, ІІ дугаар багцын тендерт шалгарсан “Бест агро интернэйшнл” ХХК, “Тэнүүн хишиг” ХХК-ний нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүнийг хуваарийн дагуу орон нутагт хүргүүлсэн. Зүүн бүсийн 3 аймгийн Мал эмнэлгийн газарт халдваргүйтгэлийн бодис 3000 кг (хлорын шохой, суперкилл, роксицид), халдвар хамгааллын нэг удаагийн иж бүрдэл 450 ширхэг, олон удаагийн халдвар хамгааллын хувцасны иж бүрдэл 30 ширхэг,	100.0

					халдваргүйтгэлийн багаж болох дулаанаар мананцаржуулагч 3 ширхэг, хүйтнээр мананцаржуулагч 3 ширхэгийг тус тус холбогдох зааврын хамт хүргүүлсэн.	
42	3.3.5. Гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины үйлдвэрлэлийн технологийн шинэчлэх;	3.3.5.1. Вирусын гаралтай вакцины үйлдвэр байгуулах, үйлдвэрлэлийн технологийг шинэчлэх;	2019 - 2021	57.5 сая ам доллар	Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Унгар Улсын Засгийн газар хооронд байгуулсан Санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий хөтөлбөрийн хэлэлцээрийн хугацаа дууссан тул 2017 онд уг зээлийн гэрээний хугацааг 2019 оны 05 дугаар сарын 11-ийг хүртэл дахин 2 жилээр сунгасан. Энэ хугацаанд “Сонгино дахь Биокомбинат ТӨҮГ-ын тоног төхөөрөмжийг шинэчлэх” тендерийг Монголын тал Унгарын холбогдох аж ахуйн нэгжүүдийн дунд нээлтэй хэлбэрээр 2 удаа зарлан 2018 оны 10 дугаар сард тендер хүлээн авахад оролцогч Унгарын аж ахуйн нэгж нь нийт 57.5 сая ам.доллараар гүйцэтгэх үнийн санал ирүүлсэн. Дээрх хэлэлцээр шинэчлэн батлагдсанаар төсөл хэрэгжих боломж бүрдсэн. Үйлдвэрлэлийн жилд мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэхэд шаардлагатай нэн яаралтай үеийн зарим вакциныг шинээр үйлдвэрлэхээр төлөвлөж, ОХУ-ын Бүх холбоотын малын эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран шүлхийн вакцины өтгөрүүлэг савлах цех нээж, туршилтын вакцин савлах ажлын зардал, өртөгийн тооцоог Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А/97 дугаар тушаалаар МЭЭГ, Биокомбинат, УМЭАЦТЛ, МЭХ, МЭЭСБУЛ-ийн эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн ажлын хэсэг хийсэн. Ажлын хэсгээс гаргасан саналыг үндэслэн Мал эмнэлгийн ерөнхий газрын 2021 оны төсөвт зардлыг тусган туршилтаар 500,0 мянган тун вакцин савлах ажлыг эхлүүлэхээр төлөвлөд байна.	90.0
43	сэргийлэх вакцины дотоодын үйлдвэрлэлийн технологийн шинэчлэлийг шат дараатай хэрэгжүүлж, вакцины хэрэгцээг дотоодоос бүрэн хангах.	3.3.5.2. Биобэлдмэлийг орон нутагт хүргэх хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийг сайжруулах;	2019 - 2021		Мал эмнэлгийн ерөнхий газраас орон нутагт вакцин, биобэлдмэл, оношлуур хүргэх нөхцөлийг сайжруулах зорилгоор 2020 онд FOTON брэндийн халаах, хөргөх бүхээг бүхий зориулалтын автомашиныг Биокомбинат УТҮГ-т нийлүүлсэн.	100.0
44		3.3.5.3. Хэрэглээнд тулгуурлан вакцины сав, баглаа боодлыг шинэчлэн сайжруулах;	2019 - 2021		1. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль 12.1.7, Мал эмнэлгийн фармокопейн өгүүлэлд заасны дагуу шошго, сав баглаа боодлыг стандартад нийцүүлэн үйлдвэрлэж байна. 2. Шингэн вакцины резинэн бөглөө, хөнгөн цагаан малгайвчийг өөрчилж, олон улсын эм үйлдвэрлэлийн стандартад нийцүүлэн, хэрэглэхэд хялбар, антисептик, асептикийг шаардлагыг хангасан бөглөө /Buthyl rubber/-тэй лонхонд савладаг технилогид шилжүүлэн савлаж байна. 3. Шингэн вакцины лонхны шилний найрлагын үзүүлэлтүүд, устөрөгчийн ионы төвшрүүлэг /ph/-ийн хэмжээг олон улсын хүн болон малын эмийн үйлдвэрлэлд тавигддаг шаардлагад нийцсэн шилэн лонхонд савлаж хэрэглээнд гаргаж байна. Үүний үр дүнд вакцины чанар нь үйлдвэрлэгчээс хэрэглэгчдэд хүрэх хүртэл бүрэн хадгалагдах боломжтой боллоо.	90.0
45		3.3.5.4. Шинээр зохион бүтээгдсэн вакцин, оношлуурыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	2019 - 2021		Мал, амьтны халдварт, зооноз өвчнөөс эмчлэн сэргийлэх ийлдсийн үйлдвэрлэлийг 2014 оноос хойш ашиглахыг зогсоосон байсан. Гэвч орон нутгийн малын эмч, мэргэжилтнүүд эмчилгээний ийлдсийг дахин ашиглах тухай саналыг удаа дараа тавьж байсан тул Мал эмнэлгийн ерөнхий газрын захиалгаар цусан халдвар, боом, колибактериозын ийлдсийг үйлдвэрлэн орон нутгийн захиалгын дагуу олгосон. Мал эмнэлгийн хүрээлэнгийн судлаачдын бүтээж, Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори болон зохиогчийн эрхээр баталгаажсан халдварт, зооноз, халдваргүй, шимэгчтэх өвчин, мах сүүний магадлан шинжилгээний 12 нэрийн 23,260 тооны оношлуурыг мал эмнэлгийн салбарын	100.0

						хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор 21 аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт нийлүүлж, ашигласан.	
ЗОРИЛТ 3							94.5
46	3.4.2. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлохтой холбогдсон чанар, эрүүл ахуй, хорио цээрийн гэрээ, хэлцэлийг гадаад улстай шинэчлэн байгуулах, өргөжүүлэх;	3.4.2.1. Экспортын эрх авсан мал төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдийн байгууламж, технологийн үйл ажиллагааны горимыг импортлогч орон болон Евразийн эдийн засгийн гишүүн орнуудын мал эмнэлгийн дүрэм, журам, норм, норматив, шаардлагад нийцүүлэн баталгаажуулах;	2019 - 2021		Худалдааны олон талт хамтын ажиллагаа өргөжин хөгжсөн байна.	Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлохтой холбогдсон чанар, эрүүл ахуй, хорио цээрийн гэрээ, хэлцэлийг гадаад улстай шинэчлэн байгуулах, өргөжүүлэх зорилтын хүрээнд Экспортын эрх авсан мал төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдийн байгууламж, технологийн үйл ажиллагааны горимыг импортлогч орон болон Евразийн эдийн засгийн гишүүн орнуудын мал эмнэлгийн дүрэм, журам, норм, норматив, шаардлагад нийцүүлэн баталгаажуулах ажлыг Дэлхий нийтийг хамарсан цар тахлын үед гэрээ, хэлэлцээрийн төвшинд хийж, бэлтгэл ажлыг хангуулж байна.	50.0
47		3.4.2.2. Махны үйлдвэрүүдэд мөрдөх мал эмнэлэг, эрүүл ахуйн шаардлага, мах, махан бүтээгдэхүүний ариун цэвэр, аюулгүй байдлыг хянан баталгаажуулах зохистой дадлыг нэвтрүүлэх;	2019 - 2021		5 үйлдвэрт нэвтрүүлсэн байна.	Худалдааны чөлөөт байдлыг өргөжүүлэх зорилгоор ОХУ, БНХАУ болон бусад 9 оронтой мал, мах, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлохтой холбоотойгоор чанар, эрүүл ахуй, хорио цээрийн гэрээ хэлэлцээр хийж, импортлогч талаас хийх хяналт шалгалт, эрсдэлийн үнэлгээний арга замын оновчтой хувилбарыг тооцон ажиллаж байна. Махны үйлдвэрүүдэд мөрдөх мал эмнэлэг, эрүүл ахуйн шаардлага, мах, махан бүтээгдэхүүний ариун цэвэр, аюулгүй байдлыг хянан баталгаажуулах зохистой дадлыг нэвтрүүлэхээр 164 үйлдвэр, цехийн үйл ажиллагааг хянан шалгаж, мэдээллийн нэгдсэн сангийн бүртгэлд оруулж, зохистой дадлыг нэвтрүүлэх, хянан магадлагаанд оруулах ажлыг Мал эмнэлгийн ерөнхий газар нь МХЕГ-тай хамтран гүйцэтгэсэн.	100.0
48		3.4.2.3. Мал, малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн гарал, үүсэл, чанар, аюулгүй байдлыг мөшгөн тогтоох нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бий болгон ажиллуулах;	2019 - 2021		Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлсэн байна.	Мал эмнэлгийн нэгдсэн системийн vet.certificate.mn гэсэн домайн хаягаар мал, амьтны эрүүл мэндийн үйлчилгээ, мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний мэдээлэл, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, улсын хэмжээнд мал эмнэлгийн 417543 ширхэг цахим гэрчилгээг иргэн аж ахуйн нэгжид олгож, хяналт тавьж ажиллав. ХХААХҮЯ, МЭЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, Швейцарын хөгжлийн агентлаг Ногоон алт- малын эрүүл мэнд төсөл, “Дижитал медик” ХХК хамтран Мал эмнэлгийн нэгдсэн системийг 21 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, 332 сумын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нар мал эмнэлгийн нэгдсэн системээс тайлан, мэдээгээ, сар, өдрөөр гаргах боломж бүрдүүлэв. Мөн мал эмнэлгийн нэгдсэн системийг нэвтрүүлэх хүрээнд Цагдаагийн ерөнхий газартай хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулж, ЦЕГ, МЭЕГ-ын дарга нар ажлын төлөвлөгөөг хамтран баталж, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хөдөө орон нутгаас бэлтгэн нийлүүлж байгаа мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг сум, дүүргийн нутаг дэвсгэрээс гадагш худалдаалах, тээвэрлэх, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах үед цагдаагийн 63 пост, мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын 10 цэгээр дамжуулан шилжилт хөдөлгөөнийг хяналтад оруулж, нийт 263141 мал эмнэлгийн гэрчилгээнд шалгаж хяналт тавьж ажиллав.	100.0
49	3.4.3.а. Экспортын зориулалттай махны үйлдвэрийг	3.4.3.1. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорноговь аймгийн Замын Үүд боомтод	2019 - 2021		Гоц халдварт өвчний гаралт	Азийн хөгжлийн банкны (АХБ)-ны санхүүжилтээр Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн лабораторийг шинээр барих тендерийг зохион байгуулж, улмаар барилгын шав тавьсан байна.	30.0

	түшиглэн худалдааны хорио цээрийн шаардлагад нийцсэн мал эмнэлгийн	мал эмнэлгийн хяналтын цэг, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн байгууламжыг байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, бодис урвалжаар хангах;			буурсан байна.		
50	хяналтын цэг, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн байгууламжийг байгуулах;	3.4.3.2. Өмнөговь, Хөвсгөл аймгийн хилийн боомтод мал эмнэлгийн хяналтын цэг, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн байгууламж байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, бодис урвалжаар хангах;	2019 - 2021			Өмнөговь аймгийн Мал эмнэлгийн газрын мэдээлснээр тус аймгийн Гашуун сухайт, Шивээхүрэн боомтод орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тээврийн хэрэгслийг халдваргүйтгэх төхөөрөмж байгуулсан байна.	50.0
51		3.4.3.3. Сүхбаатар, Дорнод аймгийн хилийн боомтод мал эмнэлгийн хяналтын цэг, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн байгууламж байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, бодис урвалжаар хангах;	2019 - 2021			Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын мэдээлснээр: Азийн хөгжлийн банкны (АХБ) санхүүжилтээр тус аймгийн "Эрэнцав" хилийн боомтод баригдаж байгаа халдваргүйтгэлийн байгууламж 60 хувийн гүйцэтгэлтэй байна. Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газрын мэдээлснээр: тус аймгийн "Баруун урт" суманд мал эмнэлгийн хяналтын цэгийн байгууламжийн гүйцэтгэл нь 40 хувьтай байна.	70.0
52	3.4.3.б. Мал, амьтны дотоодын шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах;	3.4.3.1. Хулгайн болон албан ёсны зөвшөөрлөөр агнаж байгаа Зэрлэг ан, амьтдыг шинжилгээнд хамруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;	2019 - 2021		Гоц халдварт, халдварт өвчнийг эрт илрүүлсэн байна.	Мал эмнэлгийн ерөнхий газраас БОАЖЯ-д 2019 онд илгээсэн хүсэлт, мэдэгдлийн дагуу албан ёсны зөвшөөрлөөр агнасан болон экспортод гаргах зэрлэг амьтны бүтээгдэхүүнд заавал шинжилгээ хийлгэж баталгаажуулсны дараа экспортын гэрчилгээ олгох ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хулгайгаар агнагдсан зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүнд шинжилгээ хийлгэх талаар ЦЕГ-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.	100.0
53	3.4.4. Архангай аймгийн Цахир сумын “Солонготын давааны ам”, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын “Гургын гүүр”, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын “Таацын голын гүүр”, Төв аймгийн Лүн сумын “Гүүрний	3.4.4.1. Мал эмнэлгийн хяналтын цэгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, мал, амьтны шилжилт хөдөлгөөний бүртгэлийг сайжруулах;	2019 - 2021		Мал эмнэлгийн хяналтын цэгийн үйл ажиллагаа сайжирч, гоц халдварт өвчний гаралт буурна.	Архангай аймгийн Цахир сумын Солонготын давааны ам, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Гургын гүүр, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Таацын голын гүүр, Төв аймгийн Лүн сумын Гүүрний аманд байрлах мал эмнэлэг, хорио цээрийн хяналтын цэгийг Мал эмнэлгийн нэгдсэн системд холбон доорх арга хэмжээг хэрэгжүүллээ. Үүнд: Хяналтын цэгийн албан хаагчдыг давтан сургах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах /уншигч Таблет, гэрчилгээ хэвлэгч/, өвлийн хээрийн хувцсаар хангах, 2 хяналтын цэгийг автомашинаар хангах зэрэг ажлыг хийсэн ба тухай бүр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Ингэснээр мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналт эрс сайжирч мал, амьтны шилжилт хөдөлгөөнөөр дамжин гоц халдварт, халдварт өвчин дамжин тархахаас сэргийлэн ажиллаж байна. Мал эмнэлгийн нэгдсэн системийг мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгүүдэд бүрэн нэвтрүүлж ажилласнаар мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг бүрэн хянах, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийг улам тодорхой болгон ажиллаж байна.	100.0

54	ам”-нд байгуулсан мал эмнэлгийн хяналтын цэгийн үйл ажиллагааг тогтворжуулж, хүний нөөц, техникийн бэлэн байдлыг бэхжүүлэх;	3.4.4.2. Мал эмнэлгийн хяналтын цэгийн тоног төхөөрөмжөөр хангах	2019 - 2021		Архангай аймгийн Цахир сумын “Солонготын давааны ам”, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын “Гуртын гүүр”, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын “Таацын голын гүүр”, Төв аймгийн Лүн сумын “Гүүрний ам”-нд байгуулсан мал эмнэлгийн хяналтын цэг болон Нийслэлийн мал эмнэлгийн хяналтын цэгийг мал эмнэлгийн нэгдсэн системд холбосон ба шаардлагатай тоног төхөөрөмж болох уншигч Таблет, гэрчилгээ хэвлэгчээр ханган хяналт, шалгалтыг эрчимжүүлэн ажиллаж байна. Төв аймгийн Лүн сумын Гүүрний амны болон Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Таацын голын гүүрний хяналтын цэг, Нийслэлийн мал эмнэлгийн газарт тус бүр Тоёота Приус 30 загварын автомашин олгосон. Нийслэлийн нөөц хөрөнгөөр Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо Хөндлөн уулын ар, Сонгинохайрхан дүүргийн Баруунтуруунд шаардлага хангасан иж бүрэн халдваргүйтлийн пункттэй мал эмнэлгийн хяналтын цэгийн байгууламжийг ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа ба Налайх дүүргийн 5-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороонд мал эмнэлгийн хяналтын цэг байгуулахаар газрын зөвшөөрлийг авч, геодезийн зураглал хийлгэсэн.	100.0
ЗОРИЛТ 4						77.8
55		3.5.1.1. Мэргэжлийн зөвлөлийг харьяа байгууллага болон төрийн бус байгууллагын төлөөллийн оролцуулан байгуулах;	2019 - 2021		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-294 дүгээр тушаалаар Мал эмнэлгийн мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталсан. Тус зөвлөлийн бүрэлдэхүүнд ХХААХҮЯ, Мал эмнэлгийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ, Хөдөө аж ахуйн их сургууль, Мал эмнэлгийн хүрээлэн, Монголын үндэсний мал эмнэлгийн холбоо, зөвлөх малын эмч нарын төлөөлөл орсон.	100.0
56		3.5.1.2. Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг боловсруулан батлуулах;	2019 - 2021		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-294 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтаар мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг баталсан.	100.0
57	3.5.1. Мал эмнэлгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг эхлүүлж тогтмолжуулах;	3.5.1.3. Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг хангах;	2019 - 2021	Мал эмнэлгийн салбарт мөрдөж буй хууль, журам, дүрэм үйлчилгээний нормативын хэрэгжилт сайжирна.	Мал эмнэлгийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Зөвлөлийн даргаар батлуулав. Төлөвлөгөөний дагуу 2020 оны Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар дараахь асуудлыг хэлэлцэв. 1. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 2020 оны улсын хэмжээний төлөвлөгөө, 2. Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх 2020 оны улсын хэмжээний төлөвлөгөө, 3. Мал, амьтны зарим халдварт, шимэгчтэх өвчний тархалтыг тандан судлах 2020 оны улсын хэмжээний төлөвлөгөө, 4. Малын бруцеллэз өвчинтэй тэмцэх стратеги, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, 5. Монгол улсыг үхрийн тархи сархиагтах, үхрийн цээж, ямааны годрон өвчний халдваргүй болохыг тогтоон Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагад зарлах Мал эмнэлгийн хүрээлэнгийн гэрээг ажлын явц, 6. Нийслэл хотод 2019 онд хийгдсэн 35000 үхэрт бруцеллэз өвчний халдварлалтын түвшин тогтоох тандат шинжилгээний дүн зэрэг асуудлыг хэлэлцсэн. Мэргэжлийн зөвлөлийн хурлаар Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, зарим халдварт, шимэгчтэх өвчний тархалтыг тандан судлах 2020 оны улсын хэмжээний төлөвлөгөөг хэлэлцэн, Малын ерөнхий эмч батлан хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн шийдвэр гаргав. Малын бруцеллэз өвчинтэй тэмцэх стратеги, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хэлэлцэж дахин ажлыг хэсэг томилон нарийвчилсан үнэлгээ хийж, мэргэжлийн зөвлөл, ХХААХҮ-ийн Сайдын зөвлөлийн хуралд танилцуулахаар шийдвэрлэв. Монгол улсыг үхрийн тархи	100.0

					сархиагтах, үхрийн цээж, ямааны годрон өвчний халдваргүй болохыг тогтоох гэрээт ажлын явцыг сайшааж 2021 онд dossier бэлтгэж хүргүүлэхийг ажлын хэсэгт үүрэг болгов. Нийслэл хотод 2019 онд хийгдсэн 35000 үхэрт бруцеллэз өвчний халдварлалтын түвшин тогтоох тандалтын дүнг хэлэлцэж 2025 он гэхэд нийслэлийн нутаг дэвсгэрийг малын бруцеллэз өвчингүй гэж зарлахаар бэлтгэл хангуулахаар шийдвэрлэв		
58	3.5.2. Мал эмнэлгийн клиник болон сургалтын загвар аж ахуйг шинээр байгуулж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэдлэг, ур чадвартай малын эмч бэлтгэх, давтан сургах;	3.5.2.1. Мал эмнэлгийн клиник болон сургалтын загвар аж ахуй байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх;	2019 - 2021		Мал эмнэлгийн клиник болон сургалтын загвар нэгж байгуулагдан , нийт 2500 малын эмчийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлсэн байна.	Швейцарын хамтын ажиллагааны газар болон МЭЕГ хооронд 2019 оны 08 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан 81061564 дугаартай гэрээний хүрээнд хүрээнд 2020 онд Ногоон алт-Малын эрүүл мэнд төслөөр Архангай, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Хөвсгөл, Ховд, Төв зэрэг нийт 7 аймгийн 9 суманд Мал эмнэлгийн цогцолбор барилга, байгууламжийн өргөтгөл, засвар, шинэчлэл хийхэд Ногоон алт-Малын эрүүл мэндийн төслөөс 169 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тус Мал эмнэлгийн цогцолборын барих төсвийн 50 хувийг орон нутгаас санхүүжүүлж хамтран ажиллаж байна. Мөн НҮБ-ын ХХААБ-ын Төв болон баруун бүс нутагт мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг чадавхжуулах төсөлтэй хамтран Мал эмнэлгийн үйл ажиллагааны цогцолборын зураг төсөл макет хийсэн. Цаашид энэ Мал эмнэлгийн үйл ажиллагааны цогцолборын зураг төсөл макет, зургийн дагуу орон нутагт мал эмнэлгийн цогцолбор клиник барих төлөвлөгөөтэй байна.	90.0
59		3.5.2.2. Мал эмнэлгийн клиник болон сургалтын загвар аж ахуйн төвийг түшиглэн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн 2500 малын эмчид төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтыг жил бүр зохион байгуулах;	2019 - 2021		Олон улсын Жайка төслийн хүрээнд Малын эмчийн мэргэжийн ур чадварыг хөгжүүлэх сургалт, судалгааны төв Улаанбаатар хотын Хан-уул дүүрэгт байгуулагдсан нь мал эмнэлгийн боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх, ур чадвартай боловсон хүчин бэлтгэх эхлэл болсон. БНСУ-ын буцалтгүй тусламжаар мал эмнэлгийн клиник байгуулах үйл ажиллагааг 2019 оны сүүлээс эхлүүлэн барилгын ажил, суурилуулах тоног төхөөрөмжийн ажил хэрэгжиж байна. Швейцарын хөгжлийн агентлагын Ногоон алт Малын эрүүл мэнд төслийн хүрээнд Мал эмнэлгийн цогцолбор байгуулж байна.	30.0	
60		3.5.2.3. Малын өвчний тархвар зүйн судалгаа, мал эмнэлгийн арга хэмжээний төлөвлөлтийг хийх сургалтыг зохион байгуулах;	2019 - 2021		1500 малын эмчийг сурган, шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөлт хийх нөхцөл бүрдсэн байна.	Швейцарын хамтын ажиллагааны газар болон МЭЕГ хооронд 2019 оны 08 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан 81061564 дугаартай гэрээний хүрээнд 70,9 сая төгрөгийн төсөвтэй мал эмнэлгийн салбарт хийх ажилд Монголын тархварзүйч нарын хобоо шалгарч Монголд сүүлийн 10 жилд гарсан мал, амьтны өвчнийг нэгтгэж аймаг сумаар эрэмбэлэх, газарзүйн мэдээллийг нарийвчлан тархварзүйн зураглал гаргах, нэгдсэн сан бий болгох, эпидемиологийн үнэлгээ хийх, мал эмнэлгийн мэдээллийн нэгдсэн санд оруулах, орон нутгийн малын эмч нарт тархварзүй, ArcGIS программын сургалт зохион байгуулах ажлыг гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл цар тахалтай холбоотойгоор хойшилж 2021 оны 1 дүгээр улиралд тайлан гүйцэтгэлийг авахаар ажиллаж байна.	70.0
61	3.5.3. Мал эмнэлгийн үйлчилгээний анхан шатны түвшинд ажиллах малын эмчийг захиалгаар	3.5.3.3. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх;	2019 - 2021		Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, чадавхыг	Швейцарын хамтын ажиллагааны газар болон МЭЕГ хооронд 2019 оны 08 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан 81061564 дугаартай гэрээний хүрээнд хүрээнд 2020 онд Ногоон алт-Малын эрүүл мэнд төслөөр Архангай, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Хөвсгөл, Ховд, Төв зэрэг нийт 7 аймгийн 9 суманд Мал эмнэлгийн цогцолбор барилга, байгууламжийн өргөтгөл, засвар, шинэчлэл хийхэд Ногоон алт-Малын эрүүл мэндийн төслөөс 169 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тус Мал	90.0

	бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг төрийн бус байгууллага, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай хамран хэрэгжүүлэх;				бэхжүүлсэн байна.	эмнэлгийн цогцолборын барих төсвийн 50 хувийг орон нутгаас санхүүжүүлж хамтран ажиллаж байна.	
62		3.5.4.1. Мал эмнэлгийн лабораториудын боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулах;	2019 - 2021			Мал эмнэлгийн лабораторийн боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөг боловсруулж, мал эмнэлгийн салбарын боловсон хүчний сургалт, хөгжлийн нэгдсэн төлөвлөгөөнд оруулан батлуулав.	100.0
63	3.5.4. Лабораторийн ажилтанг мэргэшүүлэх сургалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулах;	3.5.4.2. Гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн мал эмнэлгийн лабораторийн малын эмч мэргэжилтнийг сургах;	2019 - 2021		Төр хувийн хэвшлийн 2000 гаруй малын эмч, мэргэжилтэн сургалтад хамрагдсан байна.	1. НҮБ-ын Монгол улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж төсөл, АХБ-ны “Хөдөө аж ахуй, Нэмүү өртгийн сүлжээг дэмжих” техник туслалцааны төсөлтэй хамтран мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрийн малын эмч, технологич, мал эмнэлгийн улсын байцаагч, орон нутгийн мэргэжилтнүүдэд малын эрүүл мэндийг хамгаалах, хүнсний зориулалтын мал, мах бэлтгэлд баримтлах мал эмнэлэг ариун-цэврийн шаардлага, мал эмнэлэг, ариун цэврийн хяналтын чиглэлээр сургалт зохион байгуулж, нийт 21 аймгийн 267 хүн хамруулсан байна. 2. Орон нутгийн лабораторийн болон халдвартын эмч мэргэжилтэн нарт “Шүлхий өвчний дэгдэлтийн судалгаа болон биохамгаалал” 5 өдрийн цахим сургалтыг НҮБ-ын ХХААБ-тай хамтран орон нутгийн 298 эмч, мэргэжилтэнг хамруулан цахимаар хийв. НҮБ-ын ХХААБ-тай хамтран зохион байгуулах “Гахайн африкийн мялзан өвчний бэлэн байдал” цахим сургалтыг 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн нийт 25 эмч, мэргэжилтэнг хамруулан хийв.	100.0
64		3.5.4.3. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторийг түшиглэн хувийн хэвшлийн мал эмнэлгийн нэгжийн малын эмч нарыг сургах;	2019 - 2021			Мал эмнэлгийн ерөнхий газар, Мерси кор Монгол олон улсын байгууллага хамтран “Оролцооны эпидемиологи”-ийн үндэсний сургагч багш бэлтгэх хөтөлбөр амжилттай хэрэгжүүлсэн. Энэ хөтөлбөрийн хүрээнд МЭЕГ-аас 1, МЭХ-1, УМЭАЦГЛ -1, Мерси кор байгууллагаас 1, нийт 4 малын эмч Мал, амьтан ба нийгмийн эрүүл мэндийн оролцооны эпидемиологийн сүлжээ /PENAP/ хөтөлбөрийн дагуу оролцооны эпидемиологийн хэрэгжүүлэгч болсон. 2020 онд Мерси кор Монгол олон улсын байгууллагын LTS3 төслийн хүрээнд нийтдээ 40 малын эмчийг PENAPH-ийн хөтөлбөрийн дагуу оролцоот эпидемиологийн хэрэгжүүлэгч эмч болгох, сертификат олгох үе шаттай сургалт, судалгааг амжилттай хэрэгжүүлсэн. Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчдийг мэргэшүүлэх зорилгоор Мал эмнэлгийн ерөнхий газар НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран хэрэгжүүлж байгаа “Монгол улсын төв болон баруун бүс нутагт шүлхий өвчинтэй тэмцэхэд яаралтай дэмжлэг үзүүлэх” TCP/MON/3701 төслийн хүрээнд сумын Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчдэд	70.0

					гоц халдварт өвчний үед дэгдэлтийн судалгаа хийх, биохамгааллыг хэрэгжүүлэх онол, дадлага хосолсон 3 өдрийн сургалтыг нэг жилийн хугацаанд Монгол Улсын 21 аймаг, сумдын нийт 359 мэргэжилтнийг хамруулан амжилттай зохион байгуулсан байна. УМЭАЦТЛ-иос 2020 онд нийт эмч нар мал эмнэлгийн оношилгоо, судалгаа шинжилгээний лабораторийн чиг хандлага, биоаюулгүй байдал, биохамгааллын сургалтад 42 мэргэжилтэн хамрагдав. УМЭАЦТЛ-т зохион байгуулагдсан Архивын бичиг баримт боловсруулах (MNS 5140:2011) сэдэвт сургалтад хамрагдав. Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдөр “Полимеразын гинжин урвал” сэдэвт дотоод сургалтыг тус тус хийв.	
65		3.5.4.4. Аймаг, нийслэл дэхь төвлөрсөн худалдааны захын мал эмнэлгийн лабораторийн эмч мэргэжилтнийг сургах;	2019 - 2021		Махны үйлдвэр, хүнсний зах, худалдааны төв, агуулах болон тэдгээрийн дэргэдэх лабораторийг мал эмнэлгийн нэгдсэн бүртгэлд бүртгэн, мал, мах бүтээгдэхүүн хүлээн авах, хянах баталгаажуулах, бүтээгдэхүүний түгээлт зэрэг дамжлагуудыг бүртгэлжүүлэн, системийн хөгжүүлэлт хийгдэн үр дүнтэй явагдаж байна. Махны үйлдвэрийн /Meat-Factory/ шинэ модуль системийг НҮБ-ийн ХХААБ-ын Secim төслийн санхүүжилтээр боловсруулан Vet-Certificate системд холбох ажлыг зохион байгуулсан. Энэ хүрээнд мал эмнэлгийн нэгдсэн бүртгэл системийн сургалтыг тухай бүр зохион байгуулан ажилласан.	100.0
66	3.5.5. Мал эмнэлгийн лабораторийн ажилтны цалингийн зэрэглэл, урамшууллын тогтолцоо бий болгох, тогтвор суурьшилтай ажиллах_нийгмийн баталгаагаар хангах асуудлыг боловсруулж, холбогдох яам, байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	Мал эмнэлгийн байгууллагын ажилтны цалингийн зэрэглэлийг хууль, эрх зүйн хүрээнд тогтоон, холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх	2020		Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 зүйлийн 28.1 дэх заалтын дагуу Мал эмнэлгийн ерөнхий газар, аймаг, нийслэлд мал эмнэлгийн газар, сум, дүүрэгт мал эмнэлгийн тасгийг Засгийн газрын 2018 оны 267 дугаар тогтоолоор байгуулсан. Орон нутгийн Мал эмнэлгийн газар болон тасгийн бүтэц орон тоог Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А-174 дугаар тушаалаар батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулсан. Улмаар Засгийн газрын 2019 оны 275, 276 дугаар тогтоолоор Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалтны цалингийн зэрэглэлийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан Орон нутгийн мал эмнэлгийн байгууллагын Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалтны цалингийн зэрэглэлийг шинэчлэн боловсруулж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-13 дугаар тушаалаар батлуулан, мөрдүүлэн ажиллаа. Мөн мал эмнэлгийн салбарын малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох журмыг 2020 онд шинэчлэн ХХААХҮ-ийн сайдын тушаалаар баталж, уг журмын дагуу төрийн үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл олгогдож байгаа болно.	100.0
ЗОРИЛТ 5						87.5
67	3.6.2. Малчдад зориулсан мэдээллийг нээлттэй болгох замаар тэдний мэдлэгийг	3.6.2.1. Мал аж ахуйн үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа малчдын мал сүргийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх;	2019 - 2021	Малын эрүүл мэндийн харилцаанд оролцогч талуудын малын эрүүл	НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран Азийн орнуудад төдийгүй БНАХУ-д тархаад байгаа Үхрийн арьс товруутах өвчнөөс сэргийлэх, гарсан тохиолдолд хэрхэн мэдээлэл дамжуулах, өвчний үед илрэх шинж тэмдэг зэргийг багтаан сэрэмжлүүлэг анимэйшн, нугалбар 3000 хувь хэвлэж эрсдэл бүхий хилийн боомттой, шилжилт хөдөлгөөн ихээр хийгддэг аймаг, нийслэлийн малчин иргэдэд тараасан.	100.0

	дээшлүүлж, мал эмнэлгийн				мэндийн талаарх мэдлэг дээшилнэ	Зооноз өвчнөөс сэргийлэх сэрэмжлүүлэг видео танилцуулга /шторк/ бэлтгэн, цахим сайт, фэйж хуудас, you tube сайтаар дамжуулан олон нийтэд хүргээд байна.	
68	үйлчилгээнд тавих хэрэглэгчийн хяналтыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх;	3.6.2.2. Мал, амьтны шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалан гарч болох халдварт өвчний хор хөнөөл, түүнээс сэргийлэх талаар иргэн хуулийн этгээдийг ухуулга, сурталчилгаа, мэдээллээр хангах;	2019 - 2021			Мал, амьтны шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалан гарч болох халдварт өвчний хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, сум дүүрэг дэх мал эмнэлгийн тасгаар дамжуулан малчин, мал бүхий өрхүүдэд чиглэсэн ухуулга сурталчилгааг тухай бүр зохион байгуулан ажилласан ба Ковид-19 өвчнөөс шалтгаалан сургалт, сурталчилгааг хангалттай түвшинд зохион байгуулах боломж хомс байсан. Сэлэнгэ, Дархан-Уул аймгийг Үхрийн лейкоз, Өмнөговь аймгийг малын бруцеллез өвчингүй, тайван бүсээр тогтоон зарлаж тухайн аймгуудын олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлан олон нийтэд хүргүүлсэн. Мал эмнэлгийн салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор МҮОНРТ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулж, Эрүүл мал-Монголын баялаг нэвтрүүлгийн 14 хоног тутам бэлтгэн хүргэж, нийт 8 дугаар олон нийтэд хүргэж ажилласан. Малын гоц халдварт болон халдварт өвчин, зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төлөвлөгөө гаргаж, малчид ард иргэдэд сэрэмжлүүлэг 5 видео шторкыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж ажилласан.	90.0
69		3.6.2.3. Малчид, мал бүхий иргэн, хуулийн этгээдэд мал эмнэлгийн хууль, дүрэм журмыг сурталчлан, таниулах;	2019 - 2021			Сэлэнгэ, Дархан-Уул аймгийг Үхрийн лейкоз, Өмнөговь аймгийг Малын бруцеллез өвчингүй, тайван бүсээр тогтоон зарлаж тухайн аймгуудын олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлан олон нийтэд хүргүүлсэн. Мал эмнэлгийн салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор МҮОНРТ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулж, Эрүүл мал-Монголын баялаг нэвтрүүлгийг 14 хоног тутам бэлтгэж, нийт 8 дугаар гарган олон нийтэд хүргэж ажилласан. Малын гоц халдварт болон халдварт өвчин, зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төлөвлөгөө гаргаж малчид ард иргэдэд сэрэмжлүүлэг 5 видео шторкыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж ажилласан. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилт болон мал эмнэлгийн салбарын төлөвлөгөөт үйл ажиллагааг сурталчлах зорилгоор байгууллагын цахим хуудас болох www.vet.gov.mn-ээр 96, Мал эмнэлгийн ерөнхий газар нүүр хуудсанд нийт 131 мэдээ, мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэж ажилласан.	100.0
70	3.6.3. Мал, амьтны өвчлөл, мал эмнэлгийн үйлчилгээний ач холбогдлыг олон нийтэд таниулсан сургалт, сурталчилгаа зохион байгуулах.	3.6.3.1. Гоц халдварт өвчний чиглэлээр;	2019 - 2021		Хэвлэл мэдээлэл, цахим хэлбэрээр олон нийтийг мэдээллээр 2 удаа, жил бүр 1000 малчдыг сургалтад хамруулсан байна.	НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 5 төрлийн анимэйшн, сорьц бэлтгэх, илгээхэд зориулсан сургалтын 5 төрлийн видео хичээлийг цахим сайт (you tube) болон МЭЕГ-ын вэб сайт, мал эмнэлгийн лабораторийн нэгдсэн систем зэрэгт байршуулж салбарын мэргэжилтнүүдэд хүргүүлээд байна. Шүлхийн оношилгоо, сорьц бэлтгэх, тээвэрлэх чиглэлээр мэдээллийг агуулсан видео хичээлийг бэлтгэн олон нийтийн мэдээллийн цахим сүлжээгээр дамжуулан бүх нийтийн хүртээл болгоод байна. ДМАЭМБ-аас гаргасан гахайн африк мялзангийн зурагт танилцуулгыг орчуулж хэвлэхэд бэлтгэсэн. Азийн орнуудад тархаад буй үхрийн арьс товруутах өвчнөөс сэргийлэх зорилгоор нугалбар, үйлдвэрлэлд ажиллаж байгаа эмч нарт зориулсан гарын авлагыг хэвлүүлэн эрсдэл бүхий хилийн боомттой аймгуудын малын эмч нарт хүргүүлэн, сайт, пэйж хуудсанд байршуулаад байна.	100.0
12		3.6.3.2. Малаас хүнд дамжин халдварладаг өвчний чиглэлээр;	2019 - 2021			Хүн, малын халдварт өвчин (боом, галзуу)-ий тандалт, судалгаа хийх, хүн, мал эмнэлгийн салбарын хамтарсан эрсдэлийн шинжилгээ, судалгаа хийх чадавхыг сайжруулах сургалтыг 2020 оны 7-8 дугаар сард ХААИС-ийн Мал эмнэлгийн	100.0

					<p>сургуулийн халдвартын тэнхим, Мал эмнэлгийн хүрээлэн, Зоонозын өвчин судлалын үндэсний төвтэй хамтран Монгол улсын төвийн бүсийн 5 аймаг (Хөвсгөл, Булган, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул)-ийг хамруулан зохион байгуулж, хүн, мал эмнэлгийн нийт 43 мэргэжилтэн сургалтад хамруулав.</p> <p>Мал, амьтнаас хүнд дамжин халдварладаг Зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс тодорхой агуулгын хүрээнд тодорхой форматтай хүрч буй мэдээллийг бэлтгэсэн байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Цочмог ужиг явцтай бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлье! /https://www.youtube.com/watch?v=g9RJrP8P4SE/ 2. Боом өвчнөөс урьдчилан сэргийлье! /https://www.facebook.com/watch/?v=971622743352315/ 3. Эрүүл мал Монголын баялаг https://www.youtube.com/watch?v=kHlmXVUvmXU&feature=youtu.be&fbclid=IwAR39W5T0nOqx44yPIhiRVkaYc1TgJ_La-Isun2LvwJsH1xFnSrtTM58_GE 4. Тарваган тахлаас урьдчилан сэргийлье! /https://www.facebook.com/Gavsmongolia/videos/388580802109304/ 5. Мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах, отор, нүүдлийн зорилготой мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, хяналт тавих тухай /https://www.youtube.com/watch?v=ile1b86kLw&feature=youtu.be/ 	
73		3.6.3.3. Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний чиглэлээр;	2019 - 2021		<p>шинэ болон дахин сэргэж буй өвчнийг эрт илрүүлэх тандалтын нэгдсэн цахим бүртгэлийг сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын мал эмнэлгийн байгууллагуудад нэвтрүүлэх зорилгоор Мерси Кор олон улсын байгууллагатай хамтран сургалт зохион байгуулан Мерси Кор Монгол ОУБ-ын төслийн хүрээнд дөрвөн малын эмчийг PENAPH-н хөтөлбөрийн дагуу Зимбабве болон Монгол улсад ОЭ-ийн үе шаттай сургалтад хамруулж төслийн зорилтот дөрвөн аймагт судалгаа хийлгэх замаар ОЭ-ийн сургагч багшаар бэлтгэсэн. Бэлтгэгдсэн багш нараар дамжуулан 4 аймгийн 37 малын эмч (үүний дотор 26 сумаас 19 тархвар зүйч, 2 хувийн малын эмч, 6 улсын байцаагч) PENAPH-н гэрчилгээтэй ОЭ-ийг хэрэгжүүлэгч эмч болсон байна. Мал, амьтны шинэ болон дахин сэргэж байгаа өвчин оношлогоо, тандалт, тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын бэлэн байдлын ханган харъяа байгууллагууд болон аймаг нийслэлийн мал эмнэлгийн газарт зөвлөмж үзлэг тандалтыг тогтмол хийх талаар чиглэл хүргүүлж ажилласан.Швейцарын Элчин сайдын яамны Хамтын ажиллагааны газартай байгуулсан 81061564 дугаартай гэрээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Бог малын мялзан, Гахайн Африкийн мялзан өвчний Бэлэн байдлын төлөвлөгөө, оношлох аргыг стандартыг боловсруулах ажлын ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Ажлын явц нь Бог малын мялзан, Гахайн Африкийн мялзан өвчнийг оношлох аргын стандартыг Стандарт хэмжилзүйн газраар батлуулахаар бэлэн болоод байна. Бог малын мялзан, Гахайн Африкийн мялзан өвчний Бэлэн байдлын төлөвлөгөөг батлуулахад бэлэн болоод байна.</p> <p>НҮБ-ын ХХААБ-тай хамтран “Үхрийн арьс товруутах” өвчнөөс сэргийлэхэд малчин 3000, малын эмчид зориулсан 3000 нугалбар буюу нийт 6000 ширхэг нугалбар болон өвчин гарсан тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээг багтаасан гарын авлага 1000 ширхэгийг хэвлэн эрсдэл бүхий аймаг, сумдад хүргээд байна.</p>	100.0

					Шинэ болон дахин сэргэж буй өвчин малын гоц халдварт болон халдварт өвчин, зооноз өвчнөөр 5 видео шторкийг (Гоц халдварт галзуу, шүлхий, зооноз халдварт бруцеллөз, шимэгчтэх, угаалга) хийсэн.	
74	3.6.3. Мал, амьтны өвчлөл, мал эмнэлгийн үйлчилгээний ач холбогдлыг олон нийтэд таниулсан сургалт, сурталчилгаа зохион байгуулах.	3.6.3.4. Шимэгчтэх өвчний чиглэлээр;	2019 - 2021		<p>Мал эмнэлгийн хүрээлэн, Зооноз өвчин судлалын үндэсний төвтэй хамтран 21 аймаг, нийслэлийн лабораторийн шимэгч судалын эмч нарт “Лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх, шимэгчтэх өвчний оношлогооны чадавхыг дэмжих” сургалтыг бүсчлэн зохион байгуулж, мал эмнэлгийн 23, хүн эмнэлгийн 28 мэргэжилтэн хамруулав.</p> <p>Говь-Алтай аймагт Мал угаалгын ажлыг эрчимжүүлэх, хоточ нохойн эрүүл мэндийг хамгаалах, туулгалтад бүрэн хамруулах, үхрийн арьсны гуурын боловсруулалтад бүх үхрээ хамруулах талаар аймгийн “Алтай радио”-д ярилцлага өгч, байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулсан.</p> <p>Говьсүмбэр аймагт Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний чиглэлээр 2 төрлийн 180 ш гарын авлага бэлтгэж 180 малчин өрхөд хүргэсэн.</p> <p>Дархан Уул аймагт ногоон алт хөтөлбөрийн санхүүжилтээр малчдад “Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний ач холбогдол”-ын талаар малчны хотонд сургалт зохион байгуулан 4 сумын 150 гаруй малчин, мал бүхий иргэдийг хамруулсан.</p> <p>Өмнөговь аймагт Оюу толгой ХХК-ний Орон нутгийн харилцааны хэлтсээс бэлтгэн гаргадаг "Орон нутгийн сонин"-той байгуулсан гэрээний дагуу сар тутам Мал эмнэлгийн газраас малчид, иргэдэд зориулан "Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ", "Мал сүргээ шимэгчтэх өвчнөөс эрүүлжүүлэх", Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, Ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулсан ажлын явц үр дүн, Мал эмнэлгийн үйлчилгээний чадавхийг сайжруулах чиглэлээр хийгдсэн хөрөнгө оруулалт, “Шилдэг аймгаар 3 жил дараалан шалгарахад мал эмнэлгийн салбарын оруулсан хувь нэмэр, “Мал угаалга, хашаа хорооны халдваргүйтгэл-2020” нэгдсэн арга хэмжээний нээлт, малыг суурин болон зөөврийн вананд шумбуулан угаах, тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмжөөр шүршиж угаах аргуудыг үзүүлэх сургалт хийсэн. Мэдээлэл сурталчилгаа нийт – 27 /сонинд-12, Олон нийтийн телевиз-д 10, малчид иргэдэд сургалт-5/</p>	100.0
ЗОРИЛТ 6						98.6
ЗОРИЛТЫН ДУНДАЖ БУЮУ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ						90.7